



ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS
RESEARCH CENTER

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

БИД



ХААНА ЯВНА ВЭ?



ННА* 65
ДАА** 330
Б-464

БИД ХААНА ЯВНА ВЭ?

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Сан бизнес центр, 9-р давхар, Ерөнхий сайд Амарын гудамж 29
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: 976-11-321927

Факс: 976-11-321926

Цахим шуудан: info@ecrc.mn

Цахим хуудас: www.ecrc.mn
www.aimagindex.mn
www.nogoonhutuch.mn

Фэйсбүүк хуудас: www.facebook.com/ecrcmn

Твиттер хуудас: twitter.com/ursulduhchadvar

Зургийг ЭЗБӨЧСТ

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-23-940-4

© Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Бүтээлийг зөвшөөрөлгүйгээр бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, ямар нэг хадгалах системд оруулахыг хориглоно.

АГУУЛГА

ОРШИЛ	4
1. Өрсөлдөх чадвар	6
1.1. АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА	6
1.2. УЛААНБААТАР ХОТ: ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА	36
1.3. МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР	64
Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан - 2019	64
Дэлхийн дижитал өрсөлдөх чадварын тайлан - 2019	68
Дэлхийн улс орнуудын авьяас, ур чадварын тайлан - 2019	69
2. Гадаадын шууд хөрөнгө оруулалт	71
2.1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛ ХӨГЖЛИЙН ХӨДӨЛГҮҮР	73
2.2. ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ба МОНГОЛ УЛС	79
2.3. БОДЛОГО ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	99
Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн тухай	110

ОРШИЛ



Улсын Их Хурал, орон нутгийн сонгуульд оролцох сонирхолтой намууд болон нэр дэвших бодолтой хүмүүс Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн боловсруулсан судалгааны тайлангуудыг өмнөх сонгуулийн үеийнхээс хамаагүй ихээр асууж сурагласанд, мөн худалдан авч Мөрийн хөтөлбөрөө боловсруулахад ашиглахыг хичээж буйд нь олзуурхаж, энэхүү танин мэдэхүйн товхимлыг бичихээр шийдэв.

Манай судалгааны төв Монгол Улсын, Аймгуудын, Улаанбаатар хотын Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайланг олон улсын аргачлалаар 10 дахь жилдээ боловсруулан гаргаж байгаа бөгөөд улам олон хүн мэдэж, судалгааны бодит эх үүсвэр болгон ашиглах сонирхолтой болж байгаад нь баяртай байна.

Аливаа хөгжил дэвшил бүртгэл хэмжилт, дүн шинжилгээнээс эхэлдэг. Улс орны хөгжил ч ялгаагүй. Хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй. Тийм учраас бидний хөгжил бусдын адил тодорхой шалгуур үзүүлэлтээр улс орныхоо өнөөгийн байдал, чиг хандлагыг хэмжихээс эхэлнэ. Манай Төв тэрхүү хэмжүүрийг нутагшуулж чадсан бөгөөд жил тутам тайлан гаргаж байна. Эдгээр тайланг Элчин сайдын яамд, олон улсын болон судалгааны байгууллагууд түлхүү ашигладаг байсан бол сүүлийн жилүүдэд аймаг, дүүргийн Засаг дарга нар, удирдлагууд идэвхтэй ашиглах боллоо.

Гүйлтийн тамирчинд хурдаа хэмждэг секундометр, эрүүл мэндээ хянах хүнд даралтын аппарат; жингээ хасаж, аль эсвэл нэмж байгаа хүнд жинлүүр хэрэгтэй байдаг шиг аймаг, дүүрэг, улсынхаа үйл хэргийг удирдахад хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй эрхэм Танд Өрсөлдөх чадварын судалгааны эдгээр тайлан тусална гэж итгэж байна. Сонирхсон аймаг, дүүрэг, цаашилбал Монгол Улс гэдэг их айлын амьдрал ямар байгааг олон хэмжүүрээр хэмжээд гаргачихсан байгаа учир бид хаана онож, юунд илүү анхаарах шаардлагатай байна вэ, цаашлаад бусад улстай харьцуулахад хэр хэмжээнд яван вэ гэдгээ харах боломжтой. Секундометр, жинлүүр, даралтын аппарат болон метр улстөрждөггүй шиг манай судалгааны тайлан бол бодит байдлын хэмжүүр, хөгжлийн толь юм. Даралт ихэссэн үү, багассан уу гэдгийг хэлэх нь даралтын аппаратын үүрэг. Харин ихэссэн, багассаныг бодох, оношлох, эмчлэх нь тухайн хүний болон эмчийн үүрэг.

Тийм учраас цөөн, залуу хүн амтай, эрдэс баялгийн нөөц ихтэй, зах зээлд ойр, мэдээллийн технологи харьцангуй сайн хөгжиж байгаа Монгол Улсын хувьд тогтвортой бодлоготой, тууштай, зөв явбал хөгжлийн гайхамшгийг бүтээх бүрэн боломж бий. Энэхүү номыг уншиж байгаа эрхэм Таны хувь нэмэр, хичээл зүтгэл үүнд нэн чухал. Та бид хийхгүй бол хэн хийх юм бэ? Бид нэг л айлын хүүхдүүд. Дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэгтэй байхад болохгүй, бүтэхгүй зүйл үгүй билээ.

Хэмжиж чадвал хянаж чадна

Хянаж чадвал удирдаж чадна

Удирдаж чадвал хөгжүүлж чадна.

Танд амжилт хүсье!



П.Цагаан

Удирдах зөвлөлийн дарга, Ph.D